


3

Ажилчдын эрүүл мэндийг сайжруулах ажлыг зохион байгуулах



Ажлын байран дахь асуудал нь олон хүнд нэгэн зэрэг нөлөөлдөг учраас тэдгээрийг шийдвэрлэх хамгийн сайн арга нь аль болох олон хүнийг татан оролцуулах явдал юм. Ажилчдын эрүүл мэндийн ухуулагч нь бусад ажилчдыг нэг нэгэндээ туслах, ажлын байрны эрүүл ахуйн асуудлаа шийдэхэд нь сургах, энэ ажлыг зохион байгуулах үүрэг хүлээдэг. Үүний тулд тэднийг хамтад нь бүлэг болгож, эрүүл мэндээ сайжруулах урам зоригтой байлгах нь ажилчдын эрүүл мэндийн ухуулагчийн хийж чадах хамгийн чухал зүйлсийн нэг юм. Үүнд цаг хугацаа болон тэвчээр шаардагдах бөгөөд ажилчдыг өөрсдийг нь оролцогч байлгахын тулд тэднийг дэмжих хэрэгтэй юм.

Номын энэхүү бүлэгт ажилчдын эрүүл мэндийн ухуулагчид хэрэг болох мэдээллүүд орсон бөгөөд энэ нь хамт ажиллаж буй хүмүүсийг нэг бүлэг болгон, ажлын байран дахь асуудлыг хамтдаа тодорхойлох, уг асуудлын талаар илүү ихийг мэдэх, хамтран ажиллагчдадаа эрүүл мэндийн боловсрол олгох, богино болон урт хугацааны зорилтуудыг ажлын байран дээрээ хэрэгжүүлэх, эрүүл мэндийг сайжруулах арга замын талаарх мэдээллүүд болно. Энд мөн ажилчдын эрүүл мэнд, хөдөлмөр хамгааллын хороог бүрдүүлснээр ажилчдын эрүүл мэндийн ухуулагч, ХАБЭА-н мэргэжилтэн, ажил олгогч нарт болон ажилчдад хэрхэн тусалж, шаардлагатай өөрчлөлтийг аажмаар хийж болохыг заасан болно.

Ажлаа эхлэхийн өмнө дараах зүйлсийг тунгааж бодоорой. Үүнд:

- Ямар төрлийн үйл ажиллагаа явуулбал таны авахыг хүсэж буй мэдээллийг цуглуулахад хамгийн тохиромжтой байх вэ?
- Ямар төрлийн үйл ажиллагаанд та болон таны хамтран ажиллагчид цаг гаргах боломжтой вэ?
- Ямар төрлийн үйл ажиллагаа явуулбал ажилчдын хооронд холбоо харилцаа үүсгэж чадах вэ? Яавал менежер, ХАБЭА-н мэргэжилтэн болон хөршүүдийг оролцуулаад хамтын ажиллагааг өргөжүүлэх боломжтой вэ?
- Ямар төрлийн үйл ажиллагааг зохион байгуулснаар ажилчдыг өөрчлөлт хийх урам зоригтой болгох вэ?

Эдгээр үйл ажиллагаа суралцахад тань тусална

Ажилчдаас мэдээлэл цуглуулж хэлэлцүүлэг өрнүүлэх, судалгаа явуулах, газрын зураг зурах, тэмдэглэлийг хооронд нь харьцуулах гээд аль ч төрлийн үйл ажиллагааг та сонгож хэрэгжүүлсэн, энэ нь үйлдвэр бүрт харилцан адилгүй байх болно. Гэхдээ ерөнхий тулгардаг асуудлуудыг ялган гаргаж ирэх, ажил дээр хэрэгжүүлэх оновчтой шийдлийг олохын тулд дараах асуултад хариулт авах хэрэгтэй.

Үүнд:

- Ямар асуудлыг бүгд мэддэг эсвэл ихэнх ажилтан өөр хоорондоо энэ тухай хуваалцаж байна вэ?
- Эрэгтэй, эмэгтэй ажилчид ялгаатай асуудлуудыг дэвшүүлэн тавьсан уу?
- Эрүүл мэндийн ямар асуудал байнга тулгамдаж байна вэ? Аль нь хааяа тохиолдож байгаа вэ?
- Аль асуудал нь хамгийн ноцтой, хамгийн их хор хохирол учруулж байна вэ?
- Ямар асуудлыг ихэнх ажилтан илүү онцолж шийдвэрлэхийг эрмэлзэж байна вэ?
- Эдгээрээс олон нийтийн дунд удирдлагуудын анхаарлыг хамгийн их тагаж байгаа асуудал байна уу?
- Аль асуудлыг нь хамгийн хурдан, хялбар шийдвэрлэх боломжтой вэ?

Сурч мэдсэнээ бусадтай хуваалцах

Бусад ажилчидтайгаа мэдээллээ хуваалцаарай. Ялангуяа өөрийн асуудал бэрхшээл, санаа бодлыг хуваалцаж буй ажилтантай санал солилцоорой. Хамтран ажиллагчдадаа тусалснаар асуудалд анхаарлыг нь хандуулж, бие биеэ дэмжиж өөрчлөлт хийхэд туслах нь ирээдүйд илүү их өөрчлөлт хийх урам зоригийг өдөөж өгдөг. Яг энэ шалтгаанаар сүм хийд, эмэгтэйчүүдийн бүлэг, хөршүүдийн холбоо зэрэг олон нийтийн бүлгүүдтэй мэдээллээ хуваалцаарай.



Ажилчдын анхаарал хандуулж байгаа сэдвээр ярилцах

Ажилчидтай ажлын нөхцөл байдлынх нь тухай ярилцах аргаар тэднийг залхаадаг болон тэдний хувьд чухалд тооцогдох сэдвүүд байгааг олж мэднэ. Ийм ярилцлага нь үйлдвэрийн “уур амьсгалыг мэдэрч”, ажилчид нөхцөл байдлыг өөрчлөх талаар юу бодож, мэдэрч байгааг олж мэдэх боломжийг олгодог. Ингэснээр ажилчид таныг мэддэг болж, танд итгэж, та нарын хооронд нягт хамтын ажиллагаа бий болно.

Эхлээд үйлдвэрийн ажилчидтайгаа албан бусаар харилцаж эхлээрэй. Ажлын бус орчинд өрнүүлсэн яриа нь илүү аюулгүй, хялбар байж болох юм.

Та тэднээс яагаад энэ асуултыг асууж байгаа, тэдний хариултын дагуу юу хийх төлөвлөгөөтэй байгаагаа нээлттэй тодорхой ойлгуулаарай. Хэрэв хэн нэгэнд тааламжгүй санагдаж байгаа бол санал бодлоо хуваалцахыг хүчлэх хэрэггүй. Хүмүүстэй харилцахдаа, ялангуяа олон нийтийн газар болгоомжтой байхад илүүдэхгүй.

Уулзалт зохион байгуулахад бэлэн болсон бол сонирхлоороо нэгдсэн, итгэл хүлээсэн хүмүүсээ үйлдвэр дотроо жижиг бүлгүүд болгож хуваана. Тэднийг ажлаас өөр газарт урьж уулзалтаа хийнэ. Жижиг бүлгүүдтэйгээ эхлээд уулзах нь илүү зөв сонголт юм. Жижиг бүлгүүдэд өөр өөр соёл иргэншил, хэл, үндэстний төлөөлөгч болон шилжин ирсэн иргэд оролцсон байвал сайн. Эхлээд эрэгтэй, эмэгтэй хүмүүсийг тусад нь цуглуулж уулзах нь эмэгтэйчүүд өөрсдийн асуудал болгоомжлолыг чөлөөтэй илэрхийлэх боломжийг олгоно. Цагийн аясаар янз бүрийн хүмүүсийн төлөөллийг оролцуулсан бүлгүүд бие биедээ итгэх хүртлээ өсөж дэвждэг.

Ажилчидтай ярилцах үедээ хүмүүст тэднийг хамгийн ихээр зовоож буй асуудал болон тэдний хувьд хамгийн чухалд тооцогдож буй асуудлыг чөлөөтэй ярих хангалттай цаг хугацаа, орон зайг гаргаж өгөх хэрэгтэй. Ярилцаж, зохион байгуулалтад орохыг хүсэхгүй байгаа ажилчдад уужуу хандан, үйл ажиллагаанд оролцоогүйнх нь төлөө ялгаварлан гадуурхахгүй байх ёстой. Зарим хүмүүст бодол санаагаа цэгцлэн шийдвэр гаргахад нь хугацаа хэрэгтэй байдаг.

Хүмүүсийн дэвшүүлж буй зарим асуудал танд эвгүй санагдаж магадгүй. Өөрийнхөө чадлын хэрээр тэдэнд анхаарал хандуулж, хэрхэн хариулахад нь туслахыг бусад ажилчдаасаа хүсэж, дэмжлэг авч болно. Таны үүрэг бол бүх асуудлыг шийдвэрлэх биш гэдгийг санаж яваарай. Харин ч хүмүүст өөрсдийнхөө асуудлыг олж харж, өөрсдөө шийдвэрлэх шийдлийг эрж хайхад нь туслах явдал юм.

Хүмүүсээс ажлын байрны эрүүл мэндийн тухай асуухдаа та ажилчдаас өөрийнхөө хувийн эрүүл мэндийн тухай яриач гэж хүсэх хэрэгтэй. Учир нь эрүүл мэнд гэдэг ажил гээр ч, ажлын гараа ч хамаарах асуудал юм.



Дасгал**Жижиг бүлгүүдтэй ярилцах**

Жижиг бүлгүүдийг нэгээс хоёр хүн ахлан ажиллаж болно. Эсвэл танд нэгээс хоёр жижиг бүлгүүдийг ахлан ажилладаг хэд хэдэн хүн хэрэгтэй байж болох юм. Энэ нь хүмүүсийн манлайлах ур чадварыг өсгөөд зогсохгүй танд богино хугацаанд их мэдээлэл олж авахад тань тусална.

Уулзах: Ажлын талаарх асуудлаа ярилцахад эвтэйхэн, аюулгүй, хүрч очиход хялбар газрыг сонгож цөөн тооны ажилтныг нэг дор цуглуулаарай.

Асуудлаа ярилцах: Хүмүүсийн хувьд ажил дээр нь ямар бэрхшээл тулгарч байгааг асууж, анхаарлаа хандуулж буй сэдвээ хэлж саналаа хуваалц. Ямар нөхцөл байдлыг тэд аюултай гэж үзэж байгаа болон тэдэнд аюултай байх магадлал хэр их байгааг олж мэд.

Асуудал болон санал болгож буй шийдлийг сонсох: Олон ажилтан дурдаж буй асуудлаар хүн нэг бүрийн бодол саналыг анхааралтай сонсоорой. Өөр өөр ялгаатай бүлгүүдээс гарах янз бүрийн санал бодлыг олж нээ. Бүлгийн гишүүдээс эмэгтэйчүүд, хөдөө орон нутаг болон гадаадаас ирсэн, хөгжлийн бэрхшээлтэй гэх мэт ялгаварлан гадуурхалтад өртдөг хүмүүсийн санаа бодлыг онцгой анхаарал тавьж сонсоорой.

Юу олж мэдсэнээ бичиж тэмдэглэх: Бүх зүйлийг марталгүй сайн санаж байх үүднээс хэлэлцүүлэг өрнөж байх үед болон хэлэлцүүлгийн дараах өөрийн санаа бодлыг тэр даруй тэмдэглэж авах хэрэгтэй.

Үр дүнг нэгтгэх: Олон ажилтантай уулзаж ярилцсаны дараа тэдний асуулт, хариултаас юу мэдэж авснаа нэгтгэн дүгнэх хэрэгтэй. Жишээ нь: ихэнх ажилчдад тулгамдаж буй нийтлэг асуудал нь юу вэ? Аль асуудал нь ажилчдын хувьд хамгийн чухал вэ? Аль асуудлыг шийдвэрлэх хялбар шийдэл байгаа вэ?

Танд тусламж хэрэгтэй юу? Танд тусалж чадах чадвар, мэдлэг, туршлага ХАБЭА-ын мэргэжилтнүүд, үйлдвэрчний эвлэлүүд, төрийн бус байгууллагууд гээд олон хүмүүст бий. Бүлгээс тэдэнд хүрч ажиллаж чадах хэн байгааг асуу.

Санал асуулгын аргаар асуух

Санал асуулга явуулснаар ижил төрлийн мэдээллийг нэгэн зэрэг олон хүнээс цуглуулах боломж бүрдэх бөгөөд хариултыг нь харьцуулахад хялбар байдаг. Түүнчлэн санал асуулга нь оролцсон баг, бүлгүүдийн хооронд харилцаа холбоо тогтоож, бүлгийн гишүүд болон хамтран ажиллагчид хоорондоо ярилцах сэдвийг гаргаж ирдэг.

Гэвч санал асуулгын арга нарийн төвөгтэй мэдээллийг олж авахад тус багатай. Харин бүлгүүдтэй тусгайлан ярилцахад ийм мэдээллийг олж авах нь илүү дөхөм байдаг. Ажилчдын мэдрэмжийн тухай сэдэв, эсвэл тэдэнд таагүй тухгүй байдаг зүйлсийн талаарх асуултыг ганцаарчилсан ярилцлагын явцад тодруулах нь илүү тустай.



Өөрийгөө хүмүүст танилцуулж, яагаад санал асуулга явуулж байгаагаа хэлж, тэд ч туршлагаа хуваалцсанаар ажилчдын амьдрал хэрхэн сайжирч болохыг ярьж хэлж өг.

Тодорхой асуултуудыг асуу. Жишээ нь: Өнгөрсөн долоо хоногт хэдэн цаг ажилласан бэ? Хэн нэгэн хүний арьсан дээр тууралт гарсан уу? Дарга тань ариун цэврийн өрөөнд орох цагийг хязгаартай болгосон уу? гэх мэт.

Энгийн, хялбар аргаар мэдээлэл цуглуулах нь үргэлж хамгийн шилдэг шийдэл байсан юм. Хэрвээ танд цөөн энгийн асуулт байгаа бол хооллож байх үед нь асуултаа асууж, гарыг нь өргүүлээд хариултаа авч болох тул заавал санал асуулга явуулах шаардлагагүй юм.

Хэтэрхий төвөгтэй, хэцүү асуулт ашиглан санал асуулга явуулах нь саналаа цуглуулах, нэгтгэж дүн шинжилгээ хийхэд хүндрэлтэй болгодог. Ер нь хүмүүс ихэвчлэн санал асуулгад дурдсанаас илүү олон асуудлыг хөндөж ярих сонирхолтой байдаг. Янз бүрийн зүйлсийн талаар хүмүүсийн санаа

бодлыг сонсох ажлыг төлөвлөж, хариултыг тэмдэглэж аваад, тэднийг уулзалт, хэлэлцүүлэгт урьж оролцуулан, өөрсдийн санаа зовж буй асуудалд илүү анхаарах боломж олгоорой.

Санал асуулга явуулж байгаа үед хувийн мэдээллийг нууцлах нь чухал. Энэ нь танд болон санал асуулгад оролцсон ажилчдын аль алинд тустай.



Дасгал

Санал асуулга явуулах

Уулзалт: Хэд хэдэн хамтран ажиллагчдаасаа туслахыг хүс. Ажлынхаа асуудлыг ярилцахад тухтай газрыг сонгон уулз.

Гол асуудлыг ярилцах: Энэ бүрдүүлсэн багаараа хамтдаа ажилчдаас асуух асуултын жагсаалт гарга. Бүлгүүдийн хамгийн ихээр анхаарал хандуулж буй тэр асуудлаас эхлэн жагсаалт гарга. Энэ жагсаалтаас ноцтой байж болох эсвэл таны бодлоор хамгийн чухал гэж тооцсон хэд хэдэн асуултыг сонго.

Санал асуулгын асуултыг бичих: Асуултын жагсаалт үүсгэ. Ажлын байран дээрх ямар нэг асуудлыг хөндөхдөө ажилчдын хувьд энэ асуудал хэр чухал эсэх, энэ асуудлыг шийдвэрлэх талаар тэд хэр их анхаарч байгааг үргэлж

асууж тодруулж бай. Хэрвээ хэтэрхий олон асуулт бэлдсэн бол хамгийн чухал нь аль асуудал вэ гэдгийг бодох хэрэгтэй. Хариултыг ТИЙМ эсвэл ҮГҮЙ гэж бичих, аль эсвэл хариултын хэд хэдэн хувилбартай байх нь нэгтгэн дүгнэхэд илүү хялбар бөгөөд нээлттэй асуудлаас зайлсхийх боломжийг олгодог. Хэт хайрцаглаж асуухгүйгээр хүмүүсийн юу бодож байгааг үнэн мөнөөр нь олж мэдэх нь илүү чухал юм. Санал асуулгын асуултыг бэлтгэхэд оролцоогүй цөөн тооны ажилтнаар санал асуулгаа эхлээд бөглүүл. Хэрвээ тэдний хувьд асуулт ойлгомжгүй, хэт их санагдаж байгаа бол санал асуулгын асуултыг хасаж дахин бич.

Сүүлийн 1 сард танд доорх асуудлууд тохиолдсон уу?

Арьсны тууралт: Тийм/Үгүй

Зүсэлт, шарх: Тийм/Үгүй

Өвдөлт, зовуурь: Тийм/Үгүй

Амьсгал давчдах: Тийм/Үгүй

Санал асуулгыг төлөвлөх: Хүн тус

бүр хэдэн хүнээс, үйлдвэрийн аль аль хэсгээс санал асуулга авахаа төлөвлө. Багийн гишүүдтэй уулзах, санал асуулга бөглүүлэх огноог товлго. Санал асуулгын үеэр тохиолдож болох зүйлст урьдчилан бэлтгэж, дүрд орж тоглох болон бусад дасгалаар дамжуулан уулзалтад багийн гишүүдийг бэлтгэ. Санал асуулгын дараа юу хийхээ төлөвлөж эдгээр асуултууд нь танд зайлшгүй хэрэг болох мэдээллийг өгч чадах эсэхийг урьдчилан харахыг хичээ.

Санал асуулга явуулах: Зарим хүмүүс асуултаа уншиж чадахгүй байх магадлалтай тул та тэдгээр ажилчдаас газар дээр нь асуултыг асууж, хариултыг өмнөөс нь бөглөж бичих хэрэгцээ гарч мэднэ.

Бие биенээ хүлээн зөвшөөрөх: Багаараа эргэн уулзаж, цугларахдаа та бүхэн өөрсдөдөө тохиолдсон хөгжилтэй явдал, хамгийн сонирхолтой байсан хүмүүс, тулгамдсан хэцүү бэрхшээлүүдээ хуваалцан ярилцаарай.

Хэрвээ багийн гишүүдэд асуудал тохиолдсон бол бусдаасаа асууж, санал асуулгаа хялбархан явуулах ямар арга зам олсныг нь яриулаарай.

Үр дүнг нэгтгэх: Танд хангалттай их мэдээлэл цугларсны дараа бүх хариултыг нэгтгээд хооронд нь ангилж ялга. Тэгээд багийн гишүүд асуултад хариулт авч байхдаа юу олж мэдсэнийг нэгтгэ. Жишээ нь: Хүмүүсийн ажиглаж мэдсэн эсвэл биеэрээ туулсан нийтлэг бөгөөд хамгийн аюултай зүйл юу вэ? Аль аюул ослыг зөвхөн нэг бүлгийн хүмүүс хэлж байв? Ажилтай холбоотой эрүүл мэндийн ямар асуудал хүмүүст тохиолдсон байна вэ? Хүмүүсийн хамгийн их анхаарал хандуулж байгаа зүйл юу байна? Хүмүүс ажлынхаа юуг нь өөрчлөхийг хамгийн их хүсэж байна вэ?

Ажилчдын мэдэж байгаа зүйлийг олж сонс

Манай бүлэг эргономикийн тухай уулзалт хэлэлцүүлэг өрнүүлсэн юм. Бид ажлаа яаж зохион байгуулбал бэртэл гэмтэлд бага өртөх вэ гэдгээ олж мэдсэн болно. Ажилд хэрэглэх материалаа өөртөө ойрхон тавьж, биеийн хөдөлгөөнөө багасгаснаар цаашдаа бага өвдөх болно. Мөн бид сунгалтын дасгал, иллэг, биеийн дасгал хөдөлгөөн хийж эрүүл мэндээ хамгаалах талаар суралцсан юм.

Сургагч багш бидэнд нэг хөдөлгөөнөө дахин дахин давтан хийснээс үүдэн бий болох гэмтэл бэртлийн тухай ярьж байхад нь бид түүний юу ярьж байгааг маш сайн ойлгож байсан. Үүнээс болж л бидний олонхын гар нь өвддөг! Тийм учраас бид буцаж ажил дээрээ очоод “Дахин давтдаг үйлдлээс болж бэртэх нь” гэдэг сэдвээр ярихад хүмүүс их сонирхож хүлээж авна гэж бодсон. Гэтэл хүмүүс бидэнд “Буруу, буруу. Бид нар чинь үе мөчний өвчтэй байхгүй юу, энэ чинь нэг үйлдлийг олон дахин давтан үйлдэхтэй ямар ч хамаагүй. Чи илүү их ажиллаж, хөгшрөх тусам л үе мөч чинь өвддөг болно. Тэгээд энийг юу ч өөрчилж, зогсоож чадахгүй” гэж хэлцгээж байв.

Дараагийн уулзалт хэлэлцүүлгийн үеэр бид үйлдвэрийнхээ зөрүүд, хэвшмэл ойлголттой ажилчдынхаа талаар ярьж гомдол мэдүүллээ. Сургагч багш бидэнд “Хүн бүр эрүүл мэндийн тухай харилцан адилгүй мэдлэгтэй байдаг” гэдгийг тайлбарлаад, “Бидний үүрэг бол тэдэнд байгаа мэдлэгийг үнэлэхээс гадна шинэ мэдээлэл өгөхөд оршино” гэв. Хэрвээ бид хүмүүст хандан “Та нар буруу ярьж байна” гэж хэлбэл тэд цаашид биднийг сонсохоо болино. Үүний оронд бид хүмүүст шинэ мэдлэгийг ойлгуулах арга олж, энэ шинэ мэдлэг нь тэдний мэдэж байгаа ойлголттой хэрхэн уялдаж байгааг ухааруулах хэрэгтэй.

“Үе мөчний өвчин гэсэн ойлголтыг нь буруушаахын оронд бид тэднээс асуулт асууж болох юм” гэдгийг сургагч багш санал болголоо. Жишээ нь: Яг хаана чинь өвдөж байна вэ? Хатгаж өвдөж байна уу? Ядарч, сульдаж байна уу? Өвдөлтөөс гадна өөр ямар таагүй мэдрэмж мэдэрч байна? Ажлын дараа илүү их өвдөж байна уу?

Эдгээр асуултаар дамжуулан хүмүүст үе мөчний өвдөлт болон нэг зүйлийг олон давтан хийснээс болж үүсэх өвдөлтийн ялгааг ойлгуулж өгнө. Тэд өөрсдөө энэ талаар ухаарч ойлгосноос хойш шинэ мэдээлэл олж авахаар өөрсдөө тэмүүлж эхэлнэ.

Мөн сургагч багшийн хэлснээр бид хэсэг хүмүүсийг урьж авчран, шинэ санаагаа турших туршилтад оролцуулж, үр дүнг нь хамтдаа үзэх боломжтой. Хэсэг хүмүүсийг ажлын байран дээрх нөхцөл байдалдаа өөрчлөлт оруулах, ажлын завсарлагаанаар сунгалтын дасгал хийх замаар

өвдөлтөө бууруулахыг туршиж үзэхийг хүс. Ингэснээр та өөрийн шинэ санаагаа тэдэнд ойлгуулж чадна. Долоо хоногийн дараа тэдгээр хүмүүсээс биеийн байдал дээрдсэн эсэхийг асууж тодруулаарай хэмээн сургагч багш зөвлөсөн юм.

Бид сургагч багшийн зөвлөгөөг дагаснаар ажиллагчидтайгаа хамтдаа ажлаас болж бие яаж өвддөг, өвдөхийг болиулахын тулд юу хийж болохыг сурч авсан билээ. Гэхдээ бидний сурсан хамгийн том хичээл бол, бид хүмүүст шинэ зүйлийг тулгаж хэлэхээсээ илүүтэйгээр тэднийг ойлгож, тэдэнд туслах замаар илүү их үр дүнд хүрч, хүчирхэг идэвхтэй багийг бүрдүүлдгийг мэдэж авсан юм.

Дасгал зураглалаар дамжуулан мэдлэгээ хуваалцах

Бүлгийн үйл ажиллагаанд хүмүүсийг урьж оролцуулан тэднийг өөрийн эрүүл мэндийн талаарх туршлага, ажиглалт, ажлынхаа талаар ярьж өгөхийг хүсэх нь өөр хоорондоо мэдлэгээ хуваалцан ажлын байран дахь нийтлэг асуудлаа ойлгож, мэдэхэд ихээхэн нөлөөтэй юм. Үйл ажиллагааны зураглал нь тэдэнд ижил төстэй асуудлууд ямар их байгааг олж харахад тусалдаг. Энэ нь шийдлээ хурдан олох, давуу талаа олж харж шийдвэрлэх алхам хийхэд нь бүлгүүдэд тусалдаг.

Ажилчдаас илүү хэн ч тэдний биеийн байдал, ажлын орчин нөхцөлийг сайн мэдэхгүй. Биеийн аль хэсэг нь илүү өвдөж байгааг зааж өгөхийг ажилчдаас хүссэнээр бид тэдний өвдөлтийг багасгахад нь тусалж чадна.



Биеийн зураг: Энэ зургийн тусламжтайгаар та дараах асуултыг асууна. “Ажлаас шалтгаалж таны биеийн аль хэсэг өвддөг вэ?” Үйлдвэрт байгаа хүн бүр энэ зураг дээр өөрийн хариултыг өгч болно. Үйл ажиллагааг эхлэх хамгийн зөв алхам бол та эхлээд өөрөө биеийнхээ аль хэсэгт өвддөгийг хэлэх явдал юм. Энэ нь бусад ажилчдад ажлын байран дээрх өөрсдийн асуудлыг ярихад нь тус болох уур амьсгалыг бүрдүүлж өгдөг. Биеийн зургийн жишээг 221 дүгээр хуудаснаас үзнэ үү.

Танай үйлдвэрийн газрын зураг: Ажилчдад асуудлаа ярихад нь эвтэйхэн байлгахын тулд ажлын байрны газрын зураг бэлтгэ. Үйл ажиллагаа, ажил, бүсчлэлээр нь ажилчдыг гэмтээж бэртээх магадлалтай газруудыг шошго нааж тэмдэглэ. Тэр ч бүү хэл хэдэр ааштай ажилтан, бүдүүлэг дарга нарыг ч энд оруулж болно. Осол тохиолдож байсан бүх газруудыг тэмдэглэ. Энэхүү газрын зураг нь үйлдвэр доторх тухайлсан асуудал болон тодорхой хэсэгт ажилчид анхаарлаа хандуулахад тусалдаг. Үүний дараа тэдгээр тухайлсан асуудлын шийдлийг ярилцах боломжтой юм. Үйлдвэрийн газрын зургийн жишээг 333 дугаар хуудаснаас үзнэ үү.

Оршин суугаа газрын зураг: 577 дугаар хуудсанд буй Орчны бохирдлын алхалт хэмээх үйл ажиллагааг хийсний дараа бүлгээрээ хамтдаа үйлдвэр доторх ямар асуудал олон нийтийн газар руу хальж, бохирдуулж байгааг зураглаж гарган үзүүлнэ. Бохирдлын замыг зурж, хог хаягдал үйлдвэрээс гараад хаана очдог, эрүүл мэндэд ямар хор хохирол учруулдаг болохыг харьцуулах аргаар зураглан үзүүлж болно. Үйлдвэр болон олон нийт хоорондын холбоосыг зураглаж үзүүлснээр үйлдвэрийн эргэн тойрны хөршүүд хийгээд нийгмийн бүлгүүд хамтран ажилчдын компанид тусалж чадахыг ойлгуулан, улмаар үйлдвэрийн нөхцөл байдлыг сайжруулах, үйлдвэрчний эвлэлийн холбоодыг байгаль орчны асуудлыг дэмжихийг ятгаж чадна.

Дасгал

Биеийн зураглал бүтээх

Уулзах: Хамтран ажиллагчдаасаа нэг бүлгийг цуглуулаад бүх хүнд харагдахаар томхон хэмжээтэй биеийн зураг зуруул. Том цаас, тэмдэглэх үзэг, самбар, шохой, гөлгөр гадаргуутай газрын хөрс, хайрга, самар гээд ажил дээр чинь юу л байна ашигла.

Биеийн зургийн гадуур хүрээ хийх: Хүний биеийн зургийн гадуурх хүрээг цаас, самбар, газрын хөрс зэргийн аль байгаагаар дүрсэлж зур.

Тэмдэглэгээ хийж, өвдөлтийн талаар ярилцах: Ажлаас болж биеийн аль хэсэгт өвдөлт мэдрэгдэж байгааг хүний биеийн зурагт тэмдэглэхийг ажилчдаас хүс. Тэмдэглэгээг хийж дуусах үед яагаад тэр газарт тэмдэглэгээ хийснийг тэднээс тодруулж асуу. Яг ямар өвдөлт мэдэрдэг вэ? Ажлын аль үүрэг даалгавраас болж ингэж өвдөж байна вэ? Энэ өвдөлт ямар аюултай вэ? Нэг ажилтан ярьж дуусах бүрт бусад ажилчдаас ижил өвдөлт, ижил шалтгаан бий эсэхийг тухай бүрт нь нарийвчлан асуу.

Аюултай нөхцөл байдал болон шийдвэрлэх арга замын талаар ярилцах: Бүх хүн ярьж дууссаны дараа дийлэнх хүмүүст тохиолдож буй

хамгийн аюултай ноцтой зүйл нь юу вэ, юуг хялбар аргаар засаж өөрчилж болох вэ, бүлгийн зүгээс ямар зүйлийг хамгийн эхэнд засаж шийдвэрлээсэй гэж хүсэж байгаа тухай ярилцаарай. Мөн эдгээр нөхцөл байдлыг хэрхэн засаж өөрчлөх талаар санаа бодлыг нь асуугаарай.

Олж мэдсэн зүйлээ тэмдэглэх:

Хүмүүсийн өвдөлтийнхөө талаар дүрслэн хэлсэн зүйлс, аюултай байдлаас болж үүссэн өвдөлт, тэдний санал болгосон шийдлийг сайтар тэмдэглэ. Бүх хүнд уншигдахаар газар томоор бичиж бусад хүмүүс ч бас нэмж бичих боломжийг олго.



Сонгох: Хэрвээ танд олон өнгийн бал байвал асуудал бүрийг төрөлжүүлэн өөр өөр өнгөөр тэмдэглээрэй. Жишээлбэл, эргономикийн асуудлаас болсон байвал улаан өнгөөр, химийн хорт бодисоос үүдэлтэй өвдөлтийг цэнхэр өнгөөр гэх мэт. Эсвэл үйлдвэрийн хэсэг тус бүрийн ажилчид тус бүр нэг ижил өнгөөр тэмдэглэх нь тэдний нийтлэг асуудлыг олж харах боломжийг олгоно. Өнгөөр дагнаж тэмдэглэх нь нэг төрлийн асуудал илүү тархалттай байгаа эсэхийг олж харахад тусална. Мөн та шархны лент ашиглан өвдөлттэй байдаг хэсгүүдийг газрын зурагт тэмдэглэж болно.

Дасгал**Үйлдвэрийнхээ газрын зургийг зурах**

Уулзах: Ажын аюултай нөхцөл байдлын тухай ярилцахад хамгийн тохиромжтой тэр газраа цуглар. Төмхон цаас тавиад дээр нь янз бүрийн өнгийн балаар (маркер) тэмдэглэгээ хий. (эсвэл самбар, шохой ашигласан ч болно)

Том бүлгүүдийг хуваах: Жижиг бүлгүүдэд хуваагдаад тус бүртээ өөрсдийн газрын зургаа зурж хэлэлцүүлэг өрнүүл. Яг нэг ижил ажлын байрны тухай бүлэг бүхэн өөр өөрийн олж харсан өнцгөөс бусдадаа газрын зургаа тайлбарла.

Үйлдвэрийнхээ план зургийг зурах: Өндөр байшингийн орой дээрээс харж байгаа мэтээр үйлдвэрийнхээ план зургийг зурахыг ажилчдаас хүсээрэй. Үйлдвэрийн давхар бүр өөр өөрийн гэсэн зурагтай байх хэрэгтэй. Хана, хаалга, цонх болон гарц бүрийг тэмдэглээрэй. Ажлын талбай, ажлын зогсоол, машин техник, хүмүүс (дарга нар, хамт ажиллагчид) гээд бүлгийн гишүүд юу зурмаар байна, тэр бүгдийг бүгдийг нь зуруул.

Аюултай хэсгүүдийг зурагт тэмдэглэж, ярилцах: Зургийн аль хэсэгт аюултай эсвэл аюултай зүйл тохиолдож байсан эсэхийг бүлгийн гишүүдээс асуугаад зурагт тэмдэглэ. Өөр өөр өнгөөр тэмдэглээрэй. Жишээлбэл, улаан өнгөөр гал, цахилгааны утас, халтирч унамаар шал, хэврэг шат гэх зэрэг биед гэмтэл учруулж болох аюул тус бүрийг тэмдэглэнэ. Цэнхэр өнгөөр химийн бодис хэрэглэдэг газар эсвэл химийн бодисоос болж үүссэн тоостой орчныг тэмдэглэнэ. Улбар шар өнгөөр булрах, шөрмөс сунах юм уу, биеийн хүчний ачаалал хэт их хэрэглэгддэг газрыг тэмдэглэнэ. Харин шар өнгөөр биологийн аюул буюу бохирдсон ус, хүнс, бохир ариун цэврийн өрөө зэргийг тэмдэглэнэ. Ногоон өнгөөр ажилчдад учирдаг сүрдүүлэг, дарамт болон шударга бус хандлагыг тэмдэглээрэй.

Дахин нэг удаа ажиглаж нягтлах: Бүлгийн хүмүүс хамтдаа газрын зургаа дахин нэг сайтар нягталж, ямар нэг аюултай хэсгийг орхигдуулсан эсэхийг шалгана. Хэрэв орхисон байвал газрын зураг дээр үг бичиж, өнгөөр тэмдэглэж, зураг зурна. Мөн ажлын асуудлаас болж халагдсан, өвдөж чөлөө авсан хүмүүсийг тухайн хүний ажиллаж байсан хэсэгт нь газрын зураг дээр тэмдэглэнэ.

Аюулын талаарх мэдээллийг нэгтгэх: Асуултын тусламжтайгаар аюултай байдлын тухай мэдээллийг нэгтгэнэ. Аль аюул нь ихэнх ажилчдад тохиолдож байсан бэ? Аль аюул нь зөвхөн нэг бүлэг хүмүүст тохиолдож байгаа вэ? Аль аюулыг хамгийн хурцадмал асуудал гэж үзэж байна вэ?

Дасгал

Оршин суугаа газрын зураг зурах

Цаас, харандаа, үзэг, тодруулагч зэргийг ашиглан газрын зураг зурна. Эсвэл чулуу, модон саваа гэх зэргийг ашиглан газар дээр зурсан ч болох юм.

Уулзах: Ажилчид болон 576 дугаар хуудсанд байгаа Олон нийтийн байгаль орчны бохирдлын судалгааны гишүүдийг урьж эргэн тойрны айл, байгууллагууд, хүмүүс оршин суугаа хэсгүүдээр явж гэрэл зураг авна. Эдгээр бүх зураг нь газрын зураг хийхэд хэрэг болно.

Газрын зураг гаргах: Үйлдвэрүүд, айлуудын амьдардаг орчин, сургууль цэцэрлэгийн хэсэг, хүнс худалдаалах цэгүүд болон амралт чөлөөт цагийн бүх хэсгийг хамруулсан тухайн газрын зургийг хүмүүсээр зуруулна. Энэ зурагт усны эх үүсвэр, усны ай сав буюу гол горхи, нуур цөөрөм, далай тэнгис, хүнс тариалах хэсэг болон хог хаягдал, бохир ус зайлуулах систем бүгд багтсан байх учиртай. Тухайн нөхцөл байдлаас шалтгаалж зургаа том ч зурж болно, жижиг зурсан ч болно.

Байгаль орчны бохирдлын шалтгаан болон нөлөөллийг тэмдэглэх: Бохирдол тус бүрийг өөр өөр өнгө эсвэл материал ашиглан зурагт тэмдэглэнэ. Хаанаас эхэлж байгаа, газар орон нутгийн хаагуур дайран өнгөрч байгаа хийгээд хүмүүсийн эрүүл мэндэд хэрхэн нөлөөлж байгааг тэмдэглэн харуулна.

- **Байгаль орчны бохирдол хаанаас эхэлж байна:** Тухайн газар орчин, бүсэд байрлах үйлдвэрүүд агаар, ус, газрыг бохирдуулж байна уу? Байгаль орчныг чухам аль нь хэрхэн бохирдуулж байна вэ? Тэр орчны бохирдол нь яаж харагдаж байна? Зураг дээрээ бохирдол үйлдвэрийн яг хаанаас нь гарч, тухайн бүсэд хүрч ирж байгааг тэмдэглээрэй. Зарим

бохирдол хүний нүдэнд харагддаггүй гэдгийг санаарай.

• **Бохирдож байгааг илтгэх дохио, тэмдэг:** Хог хаягдал, химийн бодисыг ус руу хаядаг уу? Танд ямар нэг утаа болон химийн бодис үнэртэж эсвэл харагдаж байна уу? Тухайн орон нутгийн хүмүүс, амьтад үйлдвэрийн бохирдолтой хүрэлцэж байна уу? Хүмүүсээс бүх төрлийн бохирдлын талаар асууж, өдөр тутамд хэрхэн тэдгээр бохирдолтой нүүр тулж байгаа тухай ярилц. Та ярилцлагадаа тухайн газрын хог хаягдлыг цуглуулдаг, цэвэрлэдэг, тээвэрлэдэг, мөн дахин боловсруулдаг хүмүүсийн төлөөллийг заавал оролцуулаарай.

• **Өвчтэй хүмүүс:** Байгаль орчны бохирдлоос болж арьсны тууралт, загатнаа, астма, нөхөн үржихүйн эрхтэнтэй холбоотой асуудал, төрөлхийн гажиг, согогтой хүүхэд төрөх, хорт хавдар зэрэг эрүүл мэндийн асуудлаар гомдол мэдүүлж байгаа хүмүүсийн амьдарч буй байршлыг зурагтаа сайтар тэмдэглээрэй. Учир нь энэ бүхнийг судалгаагаар нээж илрүүлэх боломж олдож магадгүй юм. Тодорхой нэг хэсэг газарт энэ төрлийн асуудлууд “хуримтлагдсан” байна уу, үгүй юү гэдгийг сайтар анзаарч хараарай. Голдуу үйлдвэрийн ойр орчимд ийм асуудал хуримтлагдсан байх вий. Хэрвээ үйлдвэр химийн бодис болон бусад хог хаягдлаа гол руу шууд хаядаг бол тэр голын урсгалыг дагаад асуудлууд үүсэж хуримтлагдсан байх магадлалтай байдаг.

Дахин нэг удаа нягталж харах: Зургийг бүхэлд нь бүлгийн бүх хүмүүсээр дахин хянуулж ямар нэг чухал мэдээлэл мартагдсан эсэхийг ярилцаарай.



Жишээлбэл, хүмүүсийн зүгээс материалыг дахин боловсруулдаг хэсэгт олон нийт бохирдол ихтэй байдаг талаар ярьдаг учраас зурагт тэмдэглүүлэхийг хүсэж болно. Эсвэл тухайн орон нутагт хүмүүсийн оршин суугаа хэсгийг бохирдуулдаг өөр эх үүсвэр байгаа эсэхийг ярилцаарай.

Бичиг баримт болон юу сурснаа тэмдэглэх: Хэрэв таны газрын зураг цаасан дээр байгаа бол тэр цаасаа биедээ аваад яв. Харин газар дээр зурсан бол гэрэл зургийг нь аваарай. Үйлдвэрийн ажилчид, мэдээлэл бүхий бусад хүмүүс, байгаль орчин болон нийтийн эрүүл мэндийн асуудлыг хариуцсан засгийн газрын албаны хүмүүс, олон нийтийн мэдээллийн хэрэгсэл, хэвлэл мэдээлэл, орон нутгийн хүмүүстэй энэ мэдээллээ хэрхэн хуваалцах тухайгаа ярилцах хэрэгтэй. Үйлдвэрийн гадна орчны асуудлуудад хүмүүсийн анхаарлыг хандуулснаар үйлдвэрийн дотор эерэг өөрчлөлт авчрахад сайнаар нөлөөлж, дэмжлэг болж өгдөг.

Ажил ба эрүүл мэндтэй холбоотой мэдээллийг хадгалах

Ихэнх улс оронд ажлын байрны осол гэмтэл, ажилтны эрүүл мэндийн талаарх мэдээллийн тэмдэглэлийг үйлдвэрт хадгалж байх ёстой гэж хуульчилж өгсөн байдаг. Энэхүү тэмдэглэл танд үйлдвэрийн хамгийн аюултай хэсгийг олж тогтооход туслах болно. Жишээ нь, үйлдвэрийн аль хэсгээс ирсэн ажилчид ижил төрлийн өвчтэй байх, ямар төрлийн осол хамгийн ихээр тохиолддог гэх мэт. Энэ тэмдэглэлийн тусламжтайгаар та үйлдвэрийн удирдлагуудтай хамтран тухайн үйлдвэрт тохиолддог мэргэжлээс шалтгаалсан өвчлөл, осол гэмтлийн тоог бууруулах менежмент хийж чадна. Ажил олгогчоосоо эдгээр мэдээллээр хангахыг хүсэж болно.

Ихэнх ажил олгогчид энэ мэдээллийг хуваалцахаас татгалздаг. Ямар ч тохиолдолд та өөрөө ийм мэдээллийг бичиж хадгалан, бусад ажилчдаа үзүүлж тэднийг ч бас ийм тэмдэглэл хөтлөхийг зөвлөх нь зөв алхам юм. Өөрийн бичсэн эрүүл мэндийн тэмдэглэлийг хадгалахын бас нэг давуу тал нь та энэ түүхээ дараагийн ажилд орохдоо ч бас хэрэглэнэ. Ялангуяа үйлдвэрээ сольж ажилласны дараа химийн хорд өртсөнөөс болж яг хэдэн өдөр толгой тань хүчтэй өвдсөн тухай зэрэг ноцтой мэдээллээ алдаж, хаяж гэж хэрхэвч болохгүй.

Тэмдэглэлээ хадгалах

Та ажлын нөхцөл байдал, хэрэглэж байгаа химийн бодис, эрүүл мэндийн асуудалтай холбоотой шинж тэмдэг илрэх байдлын талаар бичсэн эрүүл мэндийн түүхээ хадгалах хэрэгтэй. Ялангуяа шинэ ажил эхэлж байгаа бол бүр ч чухал. Ажлын байрныхаа гэрэл зураг, дүрс бичлэг болон арьсан дээр гарсан тууралтын



зургийг авч жишээ болгон хадгалах нь их тустай байдаг. Эдгээр мэдээлэлд үндэслэж эмч таны эрүүл мэндийн байдалд дүгнэлт өгөхөд дөхөмтэй болно. Мөн эдгээр баримт нь хуульчид, ХАБЭА-н мэргэжилтнүүд, үйлдвэрчний эвлэлийн холбоод, сэтгүүлчид болон бусад хүмүүс танд туслахад хэрэг болно. Тэмдэглэлээ хадгалснаар та биеийн эрүүл мэнд, ажлын нөхцөл байдлынхаа талаар илүү тодорхой ойлгож мэдэх болно.



Номд гарах энэхүү тэмдэглэгээ нь танд ажлын байран дээрх аюул осол болон эрүүл мэндийн асуудлуудаа тэмдэглэхийг сануулах болно.

Таны эрүүл мэнд: Өөрийн эрүүл мэндийн тухай энгийн өдөр тутмын тэмдэглэл хөтлөөрэй. Эхэндээ арьс загатнах, дотор муухайрах, халуурах гэх мэтээр яг юу чинь өвдсөн, яаж өвдөж, зовуурилсан тухай бичих нь илүү хялбар байх болно. Хэрвээ та өдөр бүр бичиж байх юм бол танд юу мэдрэгдэж байгаа, өдрөөс өдөрт биед тань ямар өөрчлөлт гарч байгааг анзаарч эхэлнэ. Голдуу химийн хорын нөлөөнөөс үүсдэг толгой өвдөх, толгой эргэх, арьс загатнах, амьсгалахад хүндрэлтэй байх зэрэг бүх мэдээллээ сайтар тэмдэглээрэй. Таны

ажилтай хамааралгүй гэж боддог эрүүл мэндийн асуудлуудаа ч бас тэмдэглэх хэрэгтэй. Хэрвээ танд эмнэлгийн шинжилгээний хариу байвал хувийг өөртөө үлдээх, зургийг нь авах зэргээр өөрийнхөө аль л санаж байгаа бүх мэдээллээ бичиж тэмдэглэх нь зүйтэй.

Таны ажил ба ажил олгогчид: Шинэ ажилд орох бүртээ ажил олгогчийнхоо тухай боломжтой бүх мэдээллийг аль болох их бичиж тэмдэглэ. Компанийн нэр, одоо байгаа хаяг (хэрэв боломжтой бол ажлын байрныхаа зургийг авах хэрэгтэй) болон ажил олгогч, захирлын нэр зэрэг мэдээлэл үүнд багтана. Хэрвээ компани тань зарагдсан бол шинэ захирлынхаа нэр зэргийг тэмдэглэл дээрээ шинэчлэх хэрэгтэй. Мөн сургалт, эрүүл мэндийн үзлэг болон ажиллаж байх хугацаандаа авсан батламжуудаа тэмдэглэлдээ оруулж өгөөрэй. Ажлын явцад хэрэглэж байгаа химийн бодис, шинээр солигдсон химийн бодисыг ч мөн тэмдэглээрэй.

Өөрийн тэмдэглэлийг бусад ажилчидтайгаа хамт дахин сөхөж харах: Өөрийн эрүүл мэндэд тулгарсан асуудлыг анзаарсныхаа дараа тантай адил тэмдэглэл хөтөлдөг бусад ажилчидтайгаа хамт тэмдэглэлүүдээ харьцуулан уншиж үзээрэй. Нэг өдөр тохиолдсон ижил асуудал юу байгааг хайж үз. Энэ бүхэн юунаас шалтгаалсан байж болох вэ? Жишээлбэл, цэвэрлэгээний бодисоо солих үед бүх хүний толгой өвдсөн байхыг олж илрүүлсэн бол даргадаа аюул багатай цэвэрлэгээний бодис авахыг санал болгох чухал үндэслэлийг олж харжээ гэсэн үг. Заримдаа эрүүл ахуй, аюулгүй ажиллагааны хорооноос ажлын газар, нийт үйлдвэрийн хэмжээнд мэдээллийг цуглуулж нэгтгэдэг.

Ажлын байран дээрх аюулын хэмжээг мэдэхэд туслах

Та үйлдвэртээ ажилладаг эрүүл мэнд, аюулгүй байдлын мэргэжилтнүүдэд үйлдвэрийн ажлын байран дахь аюулыг хэмжиж, хяналт шинжилгээ хийхэд нь тусалж чадна. Нэг хэсэгт хамт ажилладаг ажилчдын жижиг бүлэг энэ ажлыг гүйцэтгэх нь их өгөөжтэй байдаг. Учир нь энэ бүх өөрчлөлтийн үр дүнд асуудал шийдэгдсэн ч бай, үгүй ч бай шийдлийг олох, хайх арга замыг бий болгоход нааштайгаар нөлөөлдөг.

Таны амьсгалж байгаа агаарт хэдий хэмжээний химийн бодис байгааг тогтоох зэрэг зарим нэг аюулыг тусгай багаж хэрэгсэл, тест ашиглан шалгаж, хэмжих боломжтой. (215 дугаар хуудаснаас химийн тестийг харж болно) Гэхдээ та өөрийн мэдрэмжид тулгуурлан маш олон хэмжилтийг хийх боломжтой юм. Та өөрөө хэмжиж болох ажлын аюул болон хэмжих аргачлалыг доор дурдлаа. Үүнд:

- **Эргономик:** Нэг төрлийн ажил хийхэд та гараа хэдэн удаа хөдөлгөж байна вэ, нэг цагт, нэг ээлжид, нэг өдөрт хэдэн үйлдэл хийж байна вэ гэдгээ тоолж гарга.
- **Халуун ба хүйтэн:** Термометр ашиглан агаарын хэм хэр халуун ба хүйтэн байгааг тооцоолж гарга.
- **Гал:** Танай үйлдвэрт галын гарц хэд байна, хэдийг нь ээлжтэй байх үед цоожилсон байна вэ гэдгийг тогтоо. (Ажлын үед нэг ч галын гарцыг цоожлох ёсгүй!)
- **Ялгаварлан гадуурхал:** Эмэгтэй болон эрэгтэй ажилчдын цалинг хооронд нь харьцуулж үз.
- **Хүчирхийлэл:** Хэдэн ажилтан даргадаа загнуулж, доромжлуулж, зодуулж байсныг тоол.
- **Жорлонгийн хүртээмж:** Үйлдвэрт нийт хэдэн жорлон байна, хэд нь цоожтой, бас хэд нь цэвэрхэн байгааг тоол.



Өнөөдөр хэдэн бооглыг зөөж байгаагаа тоолцгооё.

Химийн хорт бодис асгарах гэх мэт ажилчдыг бодит аюулд оруулсан тохиолдол бүрийг ажлын байрны осол аваарын тэмдэглэлдээ бүртгэж ав. Сард хэдэн удаа иймэрхүү осол тохиолдож байна, үйлдвэрийн аль аль хэсэгт тохиолдож байна гэдгийг сайтар тэмдэглэж ав.

Ингэснээр үйлдвэрийн аль бүсэд хэдий хугацаанд ямар давтамжтайгаар осол, аюул гардгийг тодорхойлж тооцох боломжтой. Огноо, цаг, яг юу тохиолдсон, хүн

бэртсэн эсэх, цагдаа дуудсан эсэх, мэргэжлийн хяналтаас хүн ирсэн эсэх, түргэн тусламж дуудсан эсэх гэх зэрэг хэрэг болох бүх мэдээллийг нарийн тэмдэглэх хэрэгтэй.

Эрүүл мэнд, аюулгүй байдлын хороо байгуулах

Үйлдвэртээ эрүүл мэнд, аюулгүй байдлын хороог байгуулснаар танай үйлдвэрийн ажилчид эрүүл мэнд, аюулгүй байдлын асуудлаар хандах газартай болж, энэ чиглэлээр эерэг өөрчлөлтийг хийж чадна. Эрүүл мэнд, аюулгүй байдлын хороо нь тухайн үйлдвэрт үйлдвэрчний эвлэл байгаа эсэхээс үл хамааран байгуулагдаж, ҮЭ байхгүй газарт түүнийг орлож ажиллах ёстой байдаг. Эрүүл мэнд, аюулгүй байдлын хороонд ажилчид болон удирдлагын төлөөлөл эн тэнцүү оролцоотой байх нь олонтоо. Энэ хороо нь аюулыг тодорхойлох, ажилчдад аюул ослын талаар мэдээлэх, аюул ослыг бууруулах шийдлийг олох, асуудлууд яаж шийдэгдсэн, хэрхэн сайжирсныг хянах болон ажилчид өөрсдийн эрүүл мэнд, аюулгүй байдалд анхаарч, идэвх гаргахыг нь урамшуулах зэрэг ажлыг хийж гүйцэтгэнэ.

Эрүүл мэнд, аюулгүй байдлын хороог дараах тохиолдолд ажлаа сайн хийж байна гэж үзэж болно. Үүнд:

- Ажилчдын дуу хоолой, санал бодлыг илэрхийлэх төлөөлөл тэнд орж ажилладаг.
- Ажилчдын төлөөллийг сонгуулийн зарчмаар оруулдаг.
- Ямар нэг шийтгэлээс айхгүйгээр ажилтан бүр өөрийн дуу хоолойг илэрхийлдэг.
- Өөрчлөлтийг санаачилдаг, түүнийхээ үр дүнг хардаг.
- Аюултай асуудлуудыг шийдвэрлээгүй үлдээсэн бол нэгбүрчлэн шийдвэрлэх журамтай байх.

Үйлдвэртээ эрүүл мэнд, аюулгүй байдлын хороо байгуулах ёстойг хуульчилж өгсөн байж болох юм. Та бүхэн үйлдвэрчний эвлэл юм уу, хуульчдаас хөдөлмөрийн хуулийн заалтуудад юу гэж тусгасныг асууж тодруулаарай. Хэрвээ хөдөлмөрийн хуулиар эрүүл мэнд, аюулгүй байдлын хороог үйлдвэрт байгуулах ёстой гэж заагаагүй бол та бүхэн үйлдвэрийн эзэндээ үйлдвэрт аюултай нөхцөл байдал үүсэж ажилчдад аюултай орчин бий болох, энэ асуудлыг цэгцлэхэд их зардал орохоос нь өмнө урьдаж эрүүл мэнд, аюулгүй байдлын хороог байгуульга гэж ятгах хэрэгтэй. Мөн эрүүл мэнд, аюулгүй байдлын хороо нь үйлдвэрт

ажиллах нөхцөл аюулгүй гэдгийг баталгаажуулж, үйлдвэрийн зүгээс бэлтгэх бичиг баримтад энэ тухай тусгаснаар тухайн үйлдвэрийн захиалга нэмэгдэх боломжтой байдаг. Гэхдээ эрүүл мэнд, аюулгүй байдлын хороо нь хөдөлмөрийн олон нөхцөл байдал руу бүгд рүү нь орохгүйгээр зөвхөн хязгаарлагдмал хүрээнд ажиллах хандлагатай байдаг. Жишээлбэл, хангалттай ажлын хөлсийг тогтсон цаг хугацаанд төлөх, ээлж хүлээлцэх болон нэг ээлжид ажиллах цагийг аль болох багасгах, ажилтны эрүүл мэнд болон амьдралын чанарыг сайжруулах чиглэлээр үйлдвэрийн зүгээс дорвитой ажил хийх зэрэг нь ажилчдын эрүүл мэнд, сайн сайхан байдалд хувь нэмэр оруулдаг ч эрүүл мэнд, аюулгүй байдлын хорооны үйл ажиллагаа эдгээр асуудлыг ихэвчлэн хамардаггүй.

Зөвхөн ажилчдаас бүрдсэн эрүүл мэнд, аюулгүй байдлын хороог та бүхэн өөрийн үйлдвэрт байгуулж болно. Хэрвээ ажилчдын дунд сонгууль явуулах боломжгүй бол хариуцлага хүлээх чадвартай, ажлын орчин нөхцөлийг сайжруулах эрмэлзэлтэй хүмүүсийг хайж олж болно. Удирдлагын төлөөлөл оролцоогүй албан бус хорооны хурлаар хорооны гишүүд асуудлыг хэлэлцэж, мэдээллийг ажилчдад хэрхэн түгээх талаар ярилцаж болно. Мөн хорооны хамт олон нь даргатайгаа илүү нээлттэй, өөртөө итгэлтэй харилцахад тусалдаг. Жишээлбэл, хорооны гишүүд үйлдвэрт хэрэглэдэг бүхий л химийн бодисын Хөдөлмөрийн аюулгүй байдлын бүртгэл (ХАББ)-ийг цуглуулаад, ажилчдад зориулсан сургалт зохион байгуулснаар үйлдвэрийн ажилтан бүр энэ талаар мэдлэг, мэдээлэлтэй болно. Албан ёсны эрүүл мэнд, аюулгүй байдлын хороо ч энэ ажлыг зохион байгуулах боломжтой. Танд тийм олон хүн шаардлагагүй - ердөө л ажилчдад мэдээлэл хүргэх, үйл ажиллагаандаа тэднийг оролцуулах хүсэлтэй хүчирхэг баг байхад л хангалттай.

Экспортын чиглэлийн үйлдвэрүүдэд үйлдвэрчний эвлэл байгуулах

Үйлдвэрчний эвлэлийг байгуулснаар ажилчид ажлын байрандаа илүү хүчирхэгжин, аюул багатай ажлын байр, тохь тухтай ажиллах орчин, харьцангуй өндөр цалинтай болоход тусалдаг. Ихэнх улс оронд үйлдвэрчний эвлэл байгуулах нь хуулиар зөвшөөрөгдсөн байдаг боловч зарим нэг экспортын бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг онцгой бүсийн үйлдвэрүүдэд үйлдвэрчний эвлэл байгуулах нь хууль бус гэж үздэг. Хэдий хуулиар зөвшөөрсөн ч зарим тохиолдолд орон нутгийн засаг захиргааны ажилтнууд хөдөлмөрийн хуулиа хэрэгжүүлэх, үйлдвэрчний эвлэл байгуулан ажилтны эрх ашгийг хамгаалах сонирхолгүй, аль эсвэл чадамжгүй байдаг. Ажилчид үйлдвэрчний эвлэлээ амжилттай зохион байгуулсан ч зарим үед ажил олгогч нь тэднийг үл хүлээн зөвшөөрөх болон гэрээ байгуулахаас татгалзах явдал гардаг.

Үйлдвэрчний эвлэл байгуулна гэдэг хэцүү, бэрхшээлтэй ажил боловч ардчилсан, шударга үйлдвэрчний эвлэлтэй байснаар ажилтны ажлын нөхцөл, амьдралын чанар сайжирдаг. Ажилчдын хувьд ажлын байран дээрээ өөрчлөлт хийхээр зохион байгуулалтад орох туршлага нь нэмэгдэх тусам үйлдвэрчний эвлэлийн кампанит ажил амжилтад хүрэх магадлал нэмэгдэнэ. Эрүүл мэнд, аюулгүй байдлын төлөөх тэмцэлд ч нэгэн адил хамтран ажиллагчид тань юуг өөрчлөхийг хүсэж байгааг нь сонсож, тэднийг өөрчлөлтөд оролцох, өөрчлөлтийг гардан хэрэгжүүлэхийг нь дэмжин урамшуулж байх хэрэгтэй. Танай үйлдвэрчний эвлэлийн зохион байгуулсан ажил ялалтад хүрэх бүрт дараагийн ажлаа хийх эрч хүч нэмэгдэж, эргэн тойрны хийгээд далайн чанад дахь өөр нэг үйлдвэрт ч мөн урам зориг өгч байдаг юм.

Компани эсэргүүцэж байсан ч үйлдвэрчний эвлэлээ байгуул

Гондурас улс дахь Юу Янг хувцасны үйлдвэрийн ажилчид дарамт шахалт, бага цалин, ажлын тохь тухгүй орчноос залхаж байлаа. Тэдний ойролцоо байрлах нэгэн үйлдвэрт үйлдвэрчний эвлэл нь тэмцэл хийн ялалтад хүрч, улмаар олны анхаарлыг татсан тэрхүү үйл явдал тэднийг ч бас үйлдвэрчний эвлэл байгуулах хүсэлд хөтөлжээ. Ажилчид өөрсдийн байгуулсан үйлдвэрчний эвлэлээ засгийн газраар хүлээн зөвшөөрүүлэх, үйлдвэртэй гэрээ байгуулах гэж бүтэн жил хөөцөлдсөн байна. Тэд үйлдвэрийн даргаасаа тэдний үгийг сонсохыг хүсэж, үйлдвэрийн цайны газарт эсэргүүцлээ илэрхийлэн, эв нэгдлийн тэмдэг болох хөх өнгийн туузыг үйлдвэрийн машин дээрээ нааж байв. Үдийн хоолны дараа бүх ажилчид үйлдвэрт зэрэг алхаж ирнэ. Тэгээд 5 минутын хугацаанд ажил хаялтын тэмдэгтэй завсарлага хийж зогсоцгоодог байлаа.

Ингэснээр ажилчид дарамтад орсон юм. Зарим ажилтныг хууль бусаар ажлаас халж, үйлдвэрээ хаана хэмээн заналхийлж ч байв. Гэвч үйлдвэрчний эвлэл хүчтэй байснаар ялалт байгуулан, гэрээ байгуулж чадсан билээ. Ажил олгогч нь ажилчдын цалинг нэмж, хангамжийг сайжруулж, сар бүр эрүүл мэнд, аюулгүй байдлын хорооныхонтой уулзаж байхыг зөвшөөрчээ. Энэ бол гарцаагүй том ялалт байв. Дараа нь тэр хорооныхон Юу Янгийн эзэмшдэг өөр нэг үйлдвэрт үйлдвэрчний эвлэл байгуулахад нь тусалсан юм. Тэд хамтдаа хүлээн зөвшөөрөгдөхийн төлөө тэмцэж, гэрээ байгуулж, үйлдвэрчний эвлэлийг дэмжигчдийг айлган сүрдүүлэх явдлыг таслан зогсоож чадсан. Хоёр үйлдвэрийн үйлдвэрчний эвлэлийнхэн нэгдэж, ажилчид нь харилцан туршлага солилцсоноор хэн хэндээ их тус болжээ.

Үйлдвэрчний эвлэл зохион байгуулах, үүсгэх эрх



Олон Улсын Хөдөлмөрийн Байгууллагын стандартад (589 дүгээр хуудаснаас харна уу) олон улсын түвшинд хэрэгжүүлж буй хөдөлмөрийн суурь эрхүүдийг дурдсан байдаг. Үүнд албадан хөдөлмөр эрхлүүлэх, хүүхдийн хөдөлмөрийг мөлжихийг устгах, ажлын байран дээрх ялгаварлан гадуурхлыг зогсоох болон үйлдвэрчний эвлэл зохион байгуулах, үүсгэх эрхүүд ордог. Эдгээр конвенцуудад үйлдвэрчний эвлэл зохион байгуулах эрхийн тухай онцгойлон дурдсан байдаг.

Олон Улсын Хөдөлмөрийн Байгууллагын эрх чөлөөний нийгэмлэг болон зохион байгуулах эрхийн заалт (Дугаар 87)-д дурдахдаа:

- Ажилчид болон ажил олгогч нь ҮЭ зохион байгуулах эсвэл түүнд элсэх эрхтэй.
- Ажилчид болон ажил олгогчдын байгууллага нь өөрийн гэсэн үндсэн дүрэм, журамтай байх, төлөөлөгчдөө чөлөөтэй сонгох, үйл ажиллагаа зохион байгуулах, хөтөлбөрөө боловсруулах эрхтэй.
- Засгийн газрын зүгээс ажилчид эрхээ хэрэгжүүлэх, зохион байгуулалтад орох үйл явцыг хориглох ёсгүй.
- Ажилчид, болон ажил олгогчдын байгууллага нь холбоо, эвлэлд элсэх, олон улсын байгууллагад харьяалагдах эрхтэй.
- Ажилчид болон ажил олгогчдын байгууллага нь түдгэлзүүлэх, татан буулгахаас хамгаалуулах эрхтэй.

Олон Улсын Хөдөлмөрийн Байгууллагын зохион байгуулалтад орох, хамтын хэлэлцээр хийх эрхийн тухай заалт (дугаар 98) нь үйлдвэрчний эвлэлийг аливаа ялгаварлан гадуурхсан үйлдлээс хамгаална. Ажилчид дараах зүйлсээс хамгаалагдана.

Үүнд:

- Ажилтныг ҮЭ-д элсэхийг хориглосон, ҮЭ-ийн гишүүнчлэлээсээ татгалзахыг тулгасан ажлын байрны нөхцөлөөс;
- Ажилтныг үйлдвэрчний эвлэлийн гишүүн байсных нь төлөө болон үйлдвэрчний эвлэлийн үйл ажиллагаанд оролцсоны төлөө ажлаас халахаас;

Нэгдсэн Үндэстний Байгууллага, Олон Улсын Хөдөлмөрийн Байгууллага болон бусад олон улсын байгууллагуудын гаргасан ажилчдын эрхийн тухай тайлбарыг Хавсралт А-д оруулсан болно.

Эрүүл мэндийн асуудлыг шийдэхийн төлөөх Үйлдвэрчний эвлэлийн тэмцэл

Бүр эхнээсээ л электроникийн үйлдвэрүүд ажилчдаа зохион байгуулалтад орохыг нь зогсоохыг оролддог байсан юм. Учир нь үйлдвэрийн удирдлагын зүгээс шударга цалин хөлс шаардах, ажлын сайн нөхцөл хүсэх, аюулгүй ажлын байрыг нэхэх нь тэдний хувьд хянаж удирдахад төдийгүй ашиг орлого олоход нь саад болно гэж үздэг байв. “Компаниа аварч үлдэхийн тулд заавал үйлдвэрчний эвлэлтэй байх шаардлагагүй” гэж тэд нотлохыг хичээдэг байлаа.

Гэвч Филиппиний өмнөд Лузон дахь Эдийн засгийн Онцгой бүсэд НЭксПи (NXP) үйлдвэрчний эвлэл 20 гаруй жил ажилчдаа зохион байгуулалтад оруулсаар иржээ. Удирдлагууд үйлдвэрчний эвлэлийг ахалж байгаа удирдагчдыг ажлаас нь халж, илүү өндөр цалин, тохиромжтой ажлын цаг шаардсан ажилчдыг хавчин гадуурхаж эхэлсэн байна. Үйлдвэрчний эвлэлийн ардчилсан шинж чанарыг дэмжих, тогтвортой үйл ажиллагаагаа үргэлжлүүлэхийн тулд НЭксПи дайралт бүрт хүчтэй хэвээр байсаар олон удаагийн кампанит ажилдаа ялалт байгуулжээ.

Цалин, ажлын нөхцөл байдал сайжирсан ч ажлын байрны эрүүл мэнд, аюулгүй байдлын асуудал бүрмөсөн шийдэгдэхгүй байв. Электроникийн үйлдвэр аюулгүй гэж одоо ч олонх ажилчид боддог. НЭксПи судалгаагаар дамжуулан ажилчид юунаас болж өвдөж байгааг илрүүлж чадсан ч аюулгүй, эрүүл ахуйд нийцсэн ажлын байрыг бий болгох нь одоо ч тулгамдсан асуудал хэвээр байна. Тэр ч бүү хэл, үйлдвэрт ашиглахыг хориглосон, аюултай химийн бодисууд болох тетрахлорэтилен болон

трихлортэтиленийг одоо хүртэл ашигласаар байна. Олон ажилтны сонгол муудсанаас зовж шаналж байхад НЭксПи үйлдвэрчний эвлэл компанийн удирдлагуудыг ятгаж, дуу чимээний түвшинг бууруулахын тулд арай зөөлөн дуутай үйлдвэрийн машин авхуулж чадаагүй л байна.

Хэрвээ танайд үйлдвэрчний эвлэл байхгүй бол, та нарт үүнийг байгуулахыг зөвшөөрөөгүй гэсэн үг. Хэрвээ танайд үйлдвэрчний эвлэл байдаг бол энэ нь үр дүнтэй ажиллаж чадаагүй байж магадгүй юм.

Амьдрал хүнд үед таны эрүүл мэнд мөнгөнөөс илүү чухал гэдгийг ажилчдаг ойлгуулахад хэцүү байдаг.



Хэдийгээр тэд ажлын байрандаа мэргэжлээс шалтгаалах өвчин тусахгүй байх талаар ажилчдын идэвх санаачилгыг нь урамшуулж байгаа ч тэд тийм ч идэвхтэй оролцохгүй байна.

НЭжсПи өөрийн байр суурь дээр хатуу зогсоогүй бол ямар ч үр дүнд хүрч чадахгүй байлаа. Үйлдвэрийн нөхцөл байдлыг эсэргүүцсэнийх нь төлөө үйлдвэрчний эвлэлийн тэргүүнийг баривчилж, ажлаас нь халжээ. Гэвч үйлдвэрчний эвлэлийн гишүүдийн хүчтэй дэмжлэгтэйгээр 5 сарын дараа тэдний ихэнх нь ажилдаа буцаж орж, компанийн зүгээс тэдний тавьсан шаардлагыг хүлээж авсан байна. Одоо үйлдвэрчний эвлэлийн тэргүүн ажилчдыг өөрсдийн эрүүл мэнд, аюулгүй байдлын төлөө тууштай тэмцэхийг уриалсаар байна.

Хамгийн чухал асуудлаар кампанит ажил өрнүүлэхээр төлөвлөх

Ажлын байран дээрх асуудлын талаар мэдээлэл цуглуулах нь хүмүүсийг нэг ижил сэдвээр ярьж, адил зүйлийг мэдэхэд хүргэдэг учир тэднийг хооронд нь холбож өгдөг. Энэ нь ихэнх ажилтны хувьд анх удаа тэдний ажлыг ойлгож, анхаарал тавьж, тэднийг сонсож буй тохиолдол байдаг. Бусад хүмүүст ч гэсэн өөрт нь тохиолддогтой ижил асуудал байдгийг хуваалцах нь гайхалтай туршлага болж өгдөг.

Ажилчид нэгнээ мэддэг болж, бие биедээ итгэж эхэлснээр хамтдаа юуг өөрчлөхийг хүсэж байгаагаа ярилцах боломж, нөхцөл бүрддэг. Эхлээд тэд асуудлыг тодорхойлж, үүний дараа шийдлийг ярилцаж төлөвлөдөг. Өөр өөр бүлгийн ажилчид хоорондоо ярилцаад нэг ижил асуудлыг дэвшүүлэн тавьж, шийдлийг нь олохдоо өөр өөрсдийн нөхцөл байдалд тохирсон аргыг санал болгох ч тохиолдол байна.



Дуу хоолойгоо сонго!

Алхам 1: Асуудлаа сонгох

Асар олон өөрчлөлтийг хийх шаардлага тулгарч болох юм. Гэхдээ танай баг илүү үр дүнд хүрэхийн тулд эхлээд зөвхөн нэг асуудлыг шийдэх хэрэгтэй. Юун түрүүнд хамгийн богино хугацаанд шийдэх боломжтой асуудлыг сонгож ав. Багаар ажиллаж сурахын хэрээр та бүхэн илүү хэцүү асуудлуудыг шийдвэрлэх боломжтой болно. Хэрвээ нэг дор хэд хэдэн асуудал сонгож авбал илүү хүчтэй баг бүрдүүлэх, илүү төвөгтэй кампанит ажил зохиох хэрэгтэй болдог.

Багийн гишүүд аль асуудлыг нь эхлээд шийдвэрлэх вэ гэдгээ хэлэлцэхэд дараах асуултууд туслах болно. Үүнд:

- Ихэнх ажилтанд ямар аюул тулгарч байна вэ?
- Ямар асуудал хамгийн их хор хөнөөл учруулж эсвэл хамгийн их аюул дагуулж байна вэ?


- Аль асуудлыг хамгийн богино хугацаанд шийдвэрлэх боломжтой вэ?
- Аль асуудал дээр хамтран ажиллагчдаас хамгийн их дэмжлэг хүлээх боломжтой байна вэ?
- Ямар олон нийтийн байгууллага, улстөрч, олон нийтийн байгууллагын удирдагчдаас дэмжлэг авч болох вэ?
- Орон нутгийн ямар мэдээллийн хэрэгсэл, радио, сонин, телевиз бидэнд туслах боломжтой вэ?
- Компани аль нэг хуулийг зөрчиж байгаа юу?
- Бидэнд туслах олон улсын байгууллага байна уу?

Магадгүй та асуудлаа сонгон авахаас өмнө 49-51-р хуудсанд байгаа нэмэлт мэдээллийг үзэх нь зүйтэй болов уу.



Алхам 2: Асуудлыг хэрхэн шийдвэрлэхээ сонгох


Асуудлуудыг хэрхэн шийдвэрлэх тухай жагсаалт үүсгэ. “Ажлын байран дахь эрүүл мэнд, аюулгүй байдлын асуудлыг шийдвэрлэх нь” нэртэй зургийг 17-19 дүгээр хуудаснаас үзээд хийж болох өөрчлөлтийн талаар ярилц. Гэхдээ бүлгийн гишүүдийн өгөх хариултыг хязгаарлаж хэрэггүй. Асуудлыг яаж шийдвэрлэх тухай гаргаж байгаа бүхий л шийдэлд нээлттэй бай. Ажилчдаас гарч байгаа шинэ санааг тэдний ажиллаж байгаа яг тэр үйлдвэрт нь хэрэгжүүлэхэд илүү тохиромжтой байдаг. Асуудлын шийдлийг шат дамжлага, алхам бүрээр нь бодож гарга. Хамгийн эхний алхам нь хамгийн хялбар өөрчлөлт байх нь зүйтэй. Цаашлаад илүү тогтвортой, удаан хугацааны шийдлүүд рүү шилжих хэрэгтэй. Бүлгийнхээ давуу тал, нөөц бололцоог илүү сайн дайчилж ажиллах боломжтой арга замыг сонгоорой.



Алхам 3: Өөрийн давуу тал, саад бэрхшээл, холбоотнуудаа олж харах


Хамтын хүч хэмээх давуу талаас гадна асуудлыг шийдвэрлэхэд туслах өөр ямар давуу тал ажилчдад байж болох вэ? Энэ талаар ярилцаад бичиж тэмдэглээрэй. Үүнд:

- Бидэнд ямар давуу тал байна вэ? Бидэнд харагдахуйц өөрчлөлт авчрах ямар боломж байна вэ? Ямар стратеги баримталбал ажил олгогчид нөлөөлж, өөрчлөлт хийх шийдвэр гаргуулж чадах вэ?
- Бид ямар ямар саад тогторыг давж гарах ёстой вэ? Ямар асуудал дээр ажилчид зохион байгуулалтад орох боломжтой вэ? Ажил олгогчийн холбоотнуудаас хэн нь ажилчдын шаардлагыг эсэргүүцэх бол?
- Ажил олгогчийг шахаж шаардахад тусалж чадах ямар холбоотнуудыг бид татан оролцуулах боломжтой вэ?



Алхам 4: Үйл ажиллагааг төлөвлөх

Хүмүүсийг зохион байгуулж ямар нэг үйлдэл хийнэ гэдэг бас л цаг хугацаа шаардсан ажил юм. Ялангуяа ажилчид дайралтад өртөх, ажлаас халагдахаас айж байгаа үед. Төлөвлөгөө гаргаж, хэн хэн, аль аль хэсгийг хариуцаж ажиллахыг хуваарил. Зорилт бүрийг яаж хэрэгжүүлэхээ ярилц. Амжилттай зохион байгуулсан ажил, ур чадвар, шинэ санаагаа бусадтай хуваалц. Магадгүй таны хамгийн эхний зорилт нь зохион байгуулах хороонд илүү олон гишүүнийг шинээр элсүүлэх явдал байж болох юм. Зорилт бүрийн ард хэрэгжүүлж дуусах хугацааг тодорхой тавьж, мөн дараагийн уулзалтыг хэзээ хийх тухай цаг хугацаагаа товлож, тэр цагтаа цугларан явц ямаршуу байгаа талаар ярилц.



Алхам 5: Төлөвлөгөө хэр урагшилж байна вэ

Хүн бүр зорилтынхоо төлөө ямар ямар алхам хийснээ тайлагнах хэрэгтэй. Хэдэн хүн таны шаардлагыг дэмжиж, арга хэмжээ авахад бэлэн байгаа зэрэг хүрсэн амжилтуудаа тэмдэглээрэй. Дараа нь та бүхэн хүлээсэн үр дүндээ хүрч чадсан эсэхээ эргэн хараад төлөвлөгөөгөө өөрчлөх шаардлагатай эсэхийг шийдээрэй.



Алхам 6: Хэрвээ шаардлагатай бол төлөвлөгөөгөө дахин засаж боловсруулах

Хэрвээ ажил та бүхний төлөвлөснөөр урагшилж өгөхгүй байвал яагаад гэдэгт дүн шинжилгээ хийж үзээрэй. Төлөвлөгөөг хэрэгжүүлэхийн тулд ямар өөрчлөлт хийх хэрэгтэйг болон төлөвлөгөөгөө шинэчилж, зорилтуудыг хэрэгжүүлэхийн тулд багийн гишүүн тус бүр юу хийх хэрэгтэйг бич. Юуны өмнө зорилтуудыг хэрэгжүүлж дуусах хугацааг зааж, хэзээ дахин уулзалдаж ажлаа үнэлэх болон төлөвлөгөөгөө сайжруулахаа тогт.

Хэрвээ зорилтуудаа биелүүлэхэд аль нэг гишүүнд тусламж хэрэгтэй бол ямар тусламж хэрэгтэй, хэн тэдэнд тусалж чадах тухай ярилцаарай. Аль нэг зорилтыг хариуцаж авсан ажилтан нь бусад туршлагатай зохион байгуулагч нараасаа зөвлөгөө, сургалт, дэмжлэг авснаар хэзээ ч гүйцэлдүүлж чадахгүй байсан ажлаа хүртэл хийж чаддаг. Шүүмжлэлтэй хандахаас илүүтэй дэмжигч бай. Ганц, хоёр алдаа хийлээ гээд туршлагатай, сайн зохион байгуулагч нараа алдах хэрэггүй.

Олон улсын кампанит ажил бидэнд тусалж чадах уу

Орон нутгийн болон олон улсын байгууллагууд үйлдвэрийн ажилчдад туслах боломжтой байдаг. Тэдгээр байгууллагууд үйлдвэрийн ажилчдад хэрэг болох мэдээ, мэдээлэл болон туршлагаа хуваалцдаг юм. Жишээлбэл, тэд тодорхой үйлдвэрт үйлдвэрлэсэн хувцсыг худалдаж авдаг компаниудын талаарх мэдээллийг олж өгч чадна. Мөн энэ компанийн хэрэглэдэг бүтээгдэхүүнийг хийдэг бусад үйлдвэрүүдийн хөдөлмөрийн нөхцөлийн тухай мэдээллийг ч гаргаж өгч чадна. Тодорхой үйлдвэрүүдийг хэн эзэмшдэг, хэнтэй гэрээтэй ажилладаг гэдгийг мэдэж авснаар олон улсын кампанит ажил өрнүүлэх, үйлдвэрийн ажилчдын нөхцөл байдлыг дээшлүүлэх зорилгоор компанид шахалт үзүүлэхэд хэрэг болдог.



Корпорацууд олон улсынх байж чадаж байгаа юм чинь танай кампанит ажил ч бас олон улсын түвшинд байж чадна!

Олон улсын хэмжээнд кампанит ажил өрнүүлснээр орон нутгийн ажилчдын үг дэлхий дахинд хүрч чаддаг. Экспортын чиглэлийн үйлдвэрүүдээс бүтээгдэхүүн худалдан авдаг томоохон компаниуд нь олон нийтэд “шулан мөлжигч” байгууллага гэдэг дүр төрхөөр харагдахыг хүсдэггүй. Үйлдвэрийн ажилтанд тохиолдсон бодит түүхийг өгүүлэх нь дэлхий даяар олон нийтийн дэмжлэгийг авахад ихээхэн нөлөө үзүүлдэг.

Тухайн орон нутгийн үйлдвэрийн ажилчид олон улсын хэмжээнд кампанит ажил явуулж байгаа хүмүүст юу хэрэгтэй байгаагаа хэлж ойлгуулснаар олон улсын дэмжигч, сонсогчдын чихэнд хүрч чадах хэмжээнд кампанит ажлыг явуулах боломжтой болно. Ажилчид нэг цул хүчин болж нэгдсэнээр кампанит ажил зохион байгуулагчидтай холбоо тогтооход хялбар байх болно. Үүгээр ч зогсохгүй, үйлдвэрийн ажилчид гадны үйлдвэрчний эвлэлүүд, олон нийтийн байгууллагууд, зохион байгуулалтад хараахан ороогүй байгаа ажилчид болон олон улсын кампанит ажил зохион байгуулагчидтай хүчирхэг, нягт хамтын ажиллагааг хөгжүүлэх чадвартай болдог.


Өөрчлөлтөд ялалт байгуулахын тулд үйлдэл хийх

Амжилтад хүрэх цор ганц арга зам гэж байхгүй. Олон төрлийн үйл ажиллагааг олон янзаар зохион байгуулах боломжтой. Хүссэн үр дүндээ хүрч, ажлын байран дахь асуудлыг шийдэх, ажилчдын хүчийг үүнд хандуулахын тулд өөрчлөлтийг бий болгох арга замууд нь заримдаа хурдан ялалт байгуулах эсвэл бүр олон сар, жилийн хугацаа шаардагдах ч байж мэдэх юм.

Ажилчдаа сургаж, тэдний хэрэгцээ шаардлагыг мэдэр. Бусад үйлдвэрийн ажилчид, олон нийтийн байгууллага, ажил олгогч, ажил олгогч эздийн холбоо, засгийн газар болон түүний агентлагуудын хэрэгцээ, шаардлагыг мэдэж ав.

Харилцаа холбоо тогтоо. Ажил олгогчийг тань ятгаж чадах, ядаж л та нарын эсрэг байр суурьтай биш холбоотон, олон нийтийн байгууллагын удирдагч нар болон бусад хүмүүсийг өөрийн зохион байгуулж буй ажил руу татан оролцуул. Үйлдвэрийн эзэд, засгийн газрын албаны хүмүүстэй ч бас харилцаа тогтоо. Энэ ажлыг зохион байгуулж байгаа хүний хувьд тангай хамтран ажиллаж байгаа бүх хүнд ашигтайгаар үйл ажиллагаагаа зохион байгуулах нь хамгийн том зорилт юм. Ялалт байгуулахад шаардлагатай дэмжлэгийг олж авахад бүх анхаарлаа хандуул.

Аль болох олон ажилтныг зохион байгуулалтад оруул. Үйлдвэрийн даргаасаа өөрчлөлт хийхийг шаардах, хамтдаа үйл ажиллагаа явуулахын тулд аль болох олон ажилтныг хамруул. Энэ бол ажил олгогчийн анхаарлыг татах маш үр дүнтэй арга юм. Энэ арга нь үйл ажиллагаанд оролцож байгаа ажилчдад эрсдэлтэй байж болно. Гэвч олон ажилтан оролцох тусам удирдлагадаа хүргэх дуу хоолой тань хүчтэй болж, үүнийг дагаад ажилтан бүрт оногдох эрсдэл буурдаг талтай. Удирдлагуудтай тохиролцоонд хүрэх нь таны ажил биш гэдгийг санаж яв. Ажилчдын саналыг асууж, тэднээр шийдвэр гаргуул. Ингэж байж хамт олны хүчийг нэгтгэдэг.



Бусад ажилчдын туршлагаас суралцах

Дэлхий даяар байрлах экспортын чиглэлийн үйлдвэрийн ажилчид амжилттай хэрэгжүүлсэн төрөл бүрийн үйл ажиллагааны туршлага бий. Ажлын байрны нөхцөлдөө тааруулж ажил дээрээ буюу эсхүл олон нийтийн дунд тэдгээр туршлагыг тохируулан хэрэглэж болох юм. Эдгээр үйл ажиллагааг хэсэгчлэн юм уу, бусад үйл ажиллагаатай хослуулан хэрэгжүүлэх үед хэн нэг нь хариугаа авах үйлдэл гаргавал өөрсдийгөө болон бусдыг хэрхэн хамгаалахаа ярилц.

Ажилтан нэг бүр өөрийн ажлын байраа илүү тохь тухтай, сайхан болгоход бие даасан арга хэмжээ авах, үйлдэл хийх ажлыг зохицуул. (Жишээлбэл, сандлын зөөлөвч ажил дээрээ авчрах, хөлөө амраах тулгуур хийх гэх мэт). Эсвэл тухайн бүсэд (дуу чимээ ихтэй механик цех) юм уу, үйлчилгээний тодорхой хэсэгт (үйлдвэрийн цайны газар) эсэргүүцэл зарлаж болно. Хэрэв та бүхэн үүнийг нэгэн зэрэг хийж чадах юм бол танай үйлдвэрийн дарга гарцаагүй анзаарах болно. 531 дүгээр хуудаснаас “Ажилчид илүү сайн хоол хүнс шаардаж шинэ үйлдвэрчний эвлэлтэй болсон тухай” уншина уу.



Эрүүл мэнд, аюулгүй байдлын талаар илүү сайн уншиж судал. Сурч мэдэхийн хэрээр үйлдвэрийн эзэн болон засгийн газрыг шахаж шаардах олон төрлийн аргуудыг олж мэднэ. 488 дугаар хуудаснаас “Эмэгтэй ажилчид эрүүл мэндийн сурталчилгаа хийж зохион байгуулалтад оров” хэсгийг уншина уу.

Үйлдвэрийн хэсэг бүрээс ирсэн ажилчдыг оролцуулан харилцаа, холбооны сүлжээ үүсгэ. Ажилчид мэдээлэл дамжуулан үйлдвэрт ямар химийн бодис хэрэглэж байгаа, үйлдвэр менежментийн ямар арга барилаар ажиллахаар төлөвлөж байгаа болон үйлдвэрийн янз бүрийн хэсгийн ажилчдын харилцан адилгүй туршлага, мөн бүлэг болон ажилласнаар ямар хариу арга хэмжээ авч болохыг мэдэж авдаг. 255-257 дугаар хуудаснаас “Бид одоо аюул багатай химийн бодис ашиглаж байна” гэсэн мэдээллийг уншина уу.





Нэг минут, нэг цаг, бүүр илүү урт хугацаагаар ажил хаялт зарлаж, яагаад ажил хаялт зарлах болсон шалтгаанаа дарга, үйлдвэрийн удирдлагууддаа тайлбарла. Эсвэл үйлдвэрийн хэсгүүд өөр өөр цагт ажил хаялт зарлаж болох юм. Олон ажилтан оролцох тусмаа ийм арга өндөр үр дүнд хүрнэ. Хэрвээ дэндүү цөөхөн ажилтан ажил хаявал ямар ч үр дүнд хүрэхгүй. 310 дугаар хуудаснаас “Хамтдаа зогсож, хамтаараа сэвье” хэсгийг уншина уу.

Тусгай шаардлагуудыг үйлдвэрийн даргадаа танилцуулахдаа төлөөлөгчдийг дагуулж яв. Хэзээ ч битгий ганцаараа яваарай. Эдгээр асуудлыг шийдвэрлэснээр ажил олгогчид ямар ашигтай талаар бас тайлбарлаарай. Огноо, цаг минут, хэн хэн оролцсон, юу ярьсан, ямар шийдэлд хүрсэн тухай гээд бүх мэдээллээ тэмдэглэж аваарай. Утсан дээрээ зураг авч, бичлэг хийж болно шүү.



Засгийн газрын агентлагуудад өргөдөл гомдлоо бичгээр өгч, хөдөлмөрийн хууль, ажлын байрны аюулгүй байдлын болон ялгаварлан гадуурхлын эсрэг хууль, журмыг мөрдүүлэхийг хүсэж болно. 383-385 дугаар хуудаснаас “Албадан илүү цагаар ажиллуулахын эсрэг бид хэрхэн тэмцэж ялалт байгуулав” хэсгийг уншина уу.

Хуульчдаас зөвлөгөө, дэмжлэг аваад засгийн газрыг юм уу, компанийг шүүхэд өгч болно. Шүүхэд очсон хэрэг шийдэгдтэл чамгүй хугацаа өнгөрнө. Гэхдээ шүүхийн тогтоол олон ажилтны нөхцөл байдлыг сайжруулах болно. 100-101 дүгээр хуудаснаас “Ялтас цэвэрлэх ажлаас болж Юү Ми хорт хавдар тусаж, амиа алджээ” түүхийг уншина уу.



Хэвлэл мэдээллийн хэрэгслийг өөрсдийнхөө арга хэмжээнд урьж оролцуулан, хэвлэлийн мэдээ хэрхэн бичиж бэлтгэдэг болохыг сурч, мэдэж ав. Нийгмийн сүлжээг ашиглан ажилчид болон өөр бусад сонирхож байгаа хүмүүстэй холбогдоорой. Зураг авч олон нийтэд тараа. 153-154 дүгээр хуудаснаас “Урсгал ус цайвар цэнхэр өнгөтэй болчихлоо” гэдэг мэдээллийг уншина уу.



Ажилчид орон нутгийн удирдлагууд болон эргэн тойрны хөршүүддээ үйлдвэрт гарцаагүй өөрчлөлт хийх хэрэгтэй байгааг батлан харуулж, итгүүлж чадах нийтийн сонголыг зохион байгуулаарай. 250-251 дүгээр хуудаснаас “Бид үйлдвэртээ ямар химийн бодис хэрэглэж байгааг мэдмээр байна!” гэсэн мэдээллийг уншина уу.

Үйлдвэрийн ажилчдад яг ямар асуудал тулгараад байгааг хүмүүст ойлгуулж, мэдүүлэхийн тулд олон нийтийн уулзалт, хурал, бага хурал зэргийг зохион байгуулж, тэр болгондоо засгийн газрын зүгээс төлөөлөл оролцуулж, тэднийг ямар нэг алхам хийхэд уриалах хэрэгтэй. 149 дүгээр хуудаснаас “Загварын чиг хандлагаас болж ажилчид амиа алдах ёсгүй!” гэсэн мэдээллийг уншина уу.

